

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас макро-эдийн засгийн нөхцөл байдлын төсөөлөлд суурилан дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын зорилтуудыг тодорхойлох, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлт, төсвийн орлого, зарлагад баримтлах чиглэлүүдтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжээс хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-6.1.4-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх танилцуулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Төсвийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Засгийн газар үнийн өсөлтийг бууруулах талаар судалгаа хийсэн эсэх болон цаашид авах арга хэмжээний талаар, мөн төсвийн төсөөлөлд хуримтлал бий болгох талаарх зохицуулалт тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа хэдий ч өрхийн бодит орлого буурч байгаа тул цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх, мөн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын зардал болон Засгийн газрын өрийн хэмжээ өссөн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин хүүхдийн мөнгөний санхүүжилт болон эдийн засгийн өсөлтийг хангах хүлээгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Оюутолгойн гүний уурхай болон Тавантолгойн уурхай ашиглалтад орсноор Монгол Улсад үзүүлэх үр ашиг, байгалийн баялгаас иргэдэд хүртээх өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Засгийн газрын өрийн хэмжээг нэрлэсэн үнэ цэнээр тооцсон тооцоолол болон өрийн менежмент хийж байгаа эсэх

асуудлаар, мөн Оюутолгойн болон Дубайн гэрээг цуцалснаар Монгол Улсад дунд хугацаанд үзүүлэх үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал баялаг бүтээгчдийн эх үүсвэрийн дэмжлэгийн болон төсвийн орлого, зарлагын тэнцлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Засгийн газрын өрийн хязгаар, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ болон зэсийн баяжмалд ногдох алтны хэмжээ, тооцооллын талаар тодруулан асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, эдийн засагт гарсан нааштай үзүүлэлтүүдийг тогтворжуулах, орлогыг нэмэгдүүлэх талаар дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллах, үр өгөөжийн тодорхой хэсгийг хуримтлал үүсгэх замаар хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжсэн эх үүсвэр бий болгоход анхаарах, мөн зах зээлийн зарчимд нийцсэн эрх зүйн шинэтгэлийг хийх нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН